



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ОРА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn  
Ахлах аудитор: Г.Оргилмөрөн  
Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.24 № 49

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Ц.ДЭЛГЭРМАА  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Жаргалант сумын Эрүүл мэндийн төв 2023 оны санхүүгийн тайлангийн хугацаанд гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 709,273.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 22,859.1 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна.

Мөн орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд баталсан 68,890.5 мянган төгрөгийг хүлээн авч, тогтмол зардлыг 4,796.7 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 34.6 хувиар өссөн байна.

Орхон аймгийн Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 5 ажлын хүрээнд нийт 80,500.0 мянган төгрөгөөр барилга байгууламжийн засвар, тоног төхөөрөмж, эд хогшил хүлээн авч бүртгэсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 604 дүгээр тогтоолоор Соната-7 маркийн тээврийн хэрэгслийг хүлээн авсан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг өмнөх оноос тусгай зориулалтын шилжүүлгээс гаргаж гүйцэтгэлээр буюу хамгийн сүүлд баталсан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 06 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын дагуу нэг иргэнээр тооцон төлбөрийн аргаар болон тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлж байна.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн 20 хувийн үлдэгдэл 2023 оны 7 сараас эхлэн дутуу орж ирсээр нийт 46,978.4 мянган төгрөг, тохиолдолд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн хяналтаар 10,993.5 мянган төгрөг хасагдсан байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>54,984,143.55</b>	<b>35,776,249.76</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	23,550,989.99	302,161.71
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	23,550,989.99	302,161.71
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	23,550,989.99	302,161.71
31211	Төрийн сангийн харилцах	23,550,989.99	302,161.71
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	366,377.76	23,225,447.76
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.00	22,859,070.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	366,377.76	366,377.76
3352	Хувь хүмүүсээс авах авлага	366,377.76	366,377.76
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	31,066,775.80	12,248,640.29
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	30,764,207.80	12,203,072.29
35110	Тусгай зориулалттай материал	8,018,186.00	8,018,186.00
35130	Эм боох материал	22,746,021.80	4,184,886.29
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	302,568.00	45,568.00
35420	Аж ахуйн материал	0.00	29,000.00
35460	Хүнсний материал	302,568.00	16,568.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>820,260,887.06</b>	<b>821,801,117.29</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	820,260,887.06	821,801,117.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	815,592,887.06	817,133,117.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	586,715,016.18	626,715,016.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-48,958,191.00	-78,704,861.26
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,730,000.00	84,580,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,943,611.01	-63,495,694.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	344,695,735.11	378,992,035.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-159,305,776.92	-201,835,767.94
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,968,088.00	75,848,088.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,216,104.24	-33,326,395.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	34,342,301.08	34,342,301.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,434,570.14	-5,981,603.89
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	4,668,000.00	4,668,000.00
39301	Програм хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-825,000.00	-825,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,668,000.00	4,668,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>875,245,030.61</b>	<b>857,577,367.05</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>19,373,774.18</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.00	19,373,774.18
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.00	19,373,774.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	19,373,774.18
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>875,245,030.61</b>	<b>838,203,592.87</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	875,245,030.61	838,203,592.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,132,680.00	164,132,680.00
51101	Өмч: - төрийн	164,132,680.00	164,132,680.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	556,866,082.60	519,824,644.86
51210	Өмнөх үеийн үр дүн	556,866,082.60	556,866,082.60
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-37,041,437.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	154,246,268.01	154,246,268.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>875,245,030.61</b>	<b>857,577,367.05</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,528,253,413.58</b>	<b>898,100,403.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>917,697,513.58</b>	<b>119,936,494.59</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	917,697,513.58	119,936,494.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	7,163,754.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,163,754.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	869,770,431.82	93,676,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	47,927,081.76	19,096,440.59
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>610,555,900.00</b>	<b>778,163,908.96</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	37,621,700.00	68,890,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,621,700.00	68,890,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	572,934,200.00	709,273,408.96
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	572,934,200.00	709,273,408.96
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>663,947,270.46</b>	<b>935,141,841.29</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>663,947,270.46</b>	<b>935,141,841.29</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	656,894,009.30	925,345,141.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	396,314,173.21	533,538,956.46
210101	Үндсэн цалин	263,643,952.60	326,243,089.03
210102	Нэмэгдэл	95,490,640.05	153,930,750.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,174,243.67	17,174,045.61
210104	Урамшуулал	33,005,336.89	36,191,071.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,831,117.43	66,161,670.85
210201	Тэтгэврийн даатгал	27,461,379.51	46,662,988.35
210202	Тэтгэмжийн даатгал	3,002,569.68	4,933,345.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,340,015.74	4,439,062.40
210204	Ажилгүйдлийн даатгал	547,977.13	1,236,677.28
210205	Эрүүл мэндийн даатгал	5,479,175.37	8,889,597.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,049,638.84	42,093,800.70
210301	Гэрэл, цахилгаан	6,832,042.74	4,945,495.00
210302	Түлш, халаалт	22,191,800.00	32,979,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,025,796.10	4,168,805.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,064,200.00	28,776,751.55
210401	Бичиг хэрэг	3,554,600.00	3,322,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,200,000.00	18,126,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,708,400.00	1,280,917.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,479,250.00	1,510,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,121,950.00	4,537,633.58
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	84,339,724.56	117,950,663.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,545,014.56	105,393,605.60
210502	Хоол, хүнс	10,588,010.00	12,557,058.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,206,700.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,661,650.00	28,890,300.00
210604	Урсгал засвар	13,661,650.00	28,890,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	904,000.00	611,800.00
210702	Дотоод албан томилолт	904,000.00	611,800.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,917,737.50	2,674,829.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,432,000.00	2,088,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,300.00	330,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	20,600.00	251,440.06
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	347,837.50	0.00
210807	Газрын төлбөр	0.00	5,179.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	56,811,767.76	104,646,369.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,302,223.00	6,510,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	6,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,509,544.76	92,136,069.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,053,261.16	9,796,699.30
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	5,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	6,053,261.16	4,796,699.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,053,261.16	4,796,699.30
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>864,306,143.12</u></b>	<b><u>-37,041,437.74</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>864,306,143.12</u></b>	<b><u>-37,041,437.74</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>666,612,621.73</u></b>	<b><u>762,468,592.96</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>7,163,754.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.00	7,163,754.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	0.00	7,163,754.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,163,754.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>666,612,621.73</b>	<b>755,304,838.96</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	12,935,686.73	0.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	12,935,686.73	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	37,621,700.00	68,890,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,621,700.00	68,890,500.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	616,055,235.00	686,414,338.96
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,472,435.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	613,582,800.00	686,414,338.96
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>643,061,631.74</u></b>	<b><u>785,717,421.24</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>643,061,631.74</b>	<b>785,717,421.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>633,505,102.33</b>	<b>775,920,721.94</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	409,071,590.56	518,779,310.16
210101	Үндсэн цалин	261,951,369.95	311,483,442.73
210102	Нэмэгдэл	109,940,640.05	153,930,750.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,174,243.67	17,174,045.61
210104	Урамшуулал	33,005,336.89	36,191,071.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,831,117.43	61,547,542.97
210201	Тэтгэврийн даатгал	27,461,379.51	42,048,860.47
210202	Тэтгэмжийн даатгал	3,002,569.68	4,933,345.24

210203	ҮОМШӨ-ний даатгал	2,340,015.74	4,439,062.40
210204	Ажилгүйдлийн даатгал	547,977.13	1,236,677.28
210205	Эрүүл мэндийн даатгал	5,479,175.37	8,889,597.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,049,638.84</b>	<b>42,093,800.70</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,832,042.74	4,945,495.00
210302	Түлш, халаалт	22,191,800.00	32,979,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,025,796.10	4,168,805.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,325,451.00</b>	<b>25,531,417.97</b>
210401	Бичиг хэрэг	3,715,600.00	2,286,900.00
210402	Тээвэр, шатахуун	17,860,000.00	17,706,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,708,400.00	1,137,917.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,479,250.00	1,510,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,562,201.00	2,890,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>95,974,425.00</b>	<b>83,546,069.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,810,955.00	72,967,469.50
210502	Хоол, хүнс	10,763,470.00	10,267,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	311,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20,371,142.00</b>	<b>24,125,102.10</b>
210604	Урсгал засвар	20,371,142.00	24,125,102.10
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>904,000.00</b>	<b>611,800.00</b>
210702	Дотоод албан томилот	904,000.00	611,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,977,737.50</b>	<b>1,617,629.06</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,492,000.00	1,030,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	117,300.00	330,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	20,600.00	251,440.06
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	347,837.50	0.00
210807	Газрын төлбөр	0.00	5,179.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>18,068,049.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	18,068,049.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,556,529.41</b>	<b>9,796,699.30</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,503,268.25</b>	<b>5,000,000.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,503,268.25	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	5,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,053,261.16</b>	<b>4,796,699.30</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,053,261.16	4,796,699.30
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>23,550,989.99</u></b>	<b><u>-23,248,828.28</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>23,550,989.99</b>	<b>-23,248,828.28</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>23,550,989.99</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>23,550,989.99</b>	<b>302,161.71</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,132,680.00	154,246,268.01	-307,440,060.52	10,938,887.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,132,680.00	154,246,268.01	-307,440,060.52	10,938,887.49
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	864,306,143.12	864,306,143.12
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,132,680.00	154,246,268.01	556,866,082.60	875,245,030.61
D01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>164,132,680.00</b>	<b>154,246,268.01</b>	<b>556,866,082.60</b>	<b>875,245,030.61</b>
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>164,132,680.00</b>	<b>154,246,268.01</b>	<b>556,866,082.60</b>	<b>875,245,030.61</b>
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-37,041,437.74	-37,041,437.74
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>164,132,680.00</b>	<b>154,246,268.01</b>	<b>519,824,644.86</b>	<b>838,203,592.87</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,117,987,300.00	780,920,721.94
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,117,987,300.00	780,920,721.94
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,112,987,300.00	775,920,721.94
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	806,033,500.00	518,779,310.16
210101	Үндсэн цалин	581,155,800.00	311,483,442.73
210102	Нэмэгдэл	157,901,200.00	153,930,750.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,000,000.00	17,174,045.61
210104	Урамшуулал	48,976,500.00	36,191,071.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	94,795,200.00	61,547,542.97
210201	Тэтгэврийн даатгал	65,060,000.00	42,048,860.47
210202	Тэтгэмжийн даатгал	7,433,500.00	4,933,345.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,946,800.00	4,439,062.40
210204	Ажилгүйдлийн даатгал	1,487,300.00	1,236,677.28
210205	Эрүүл мэндийн даатгал	14,867,600.00	8,889,597.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,890,500.00	42,093,800.70
210301	Гэрэл, цахилгаан	9,066,800.00	4,945,495.00
210302	Түлш, халаалт	32,979,600.00	32,979,500.00
210303	Цэвэр, бохир ус	4,844,100.00	4,168,805.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,215,600.00	25,531,417.97
210401	Бичиг хэрэг	3,000,000.00	2,286,900.00
210402	Тээвэр, шатахуун	17,706,000.00	17,706,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,510,000.00	1,137,917.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,199,600.00	1,510,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	2,890,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	87,282,700.00	83,546,069.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	68,940,000.00	72,967,469.50
210502	Хоол, хүнс	15,349,600.00	10,267,600.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,993,100.00	311,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	24,518,800.00	24,125,102.10
210604	Урсгал засвар	24,518,800.00	24,125,102.10
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	787,200.00	611,800.00
210702	Дотоод албан томилолт	787,200.00	611,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,847,000.00	1,617,629.06
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,080,000.00	1,030,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	397,000.00	330,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	251,440.06
210807	Газрын төлбөр	750,000.00	5,179.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	18,616,800.00	18,068,049.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,616,800.00	18,068,049.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,000,000.00	5,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,000,000.00	5,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	5,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,117,987,300.00	757,671,893.66
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	68,890,500.00	64,093,800.70
132001	Орон нутгийн төсвөөс	68,890,500.00	64,093,800.70
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,025,545,800.00	686,414,338.96
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,025,545,800.00	686,414,338.96
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	23,551,000.00	7,163,754.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,163,754.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	23,551,000.00	0.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>23,550,989.99</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>302,161.71</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	24.00	22.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>22.00</b>	<b>22.00</b>
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	16.00	16.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 22,300.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 22,300.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 604 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Мэргэжлийн хяналтын газраас /хуучин/ шилжүүлэн авсан Соната-7 маркийн, 2010 онд үйлдвэрлэж, 2011 онд Монгол Улсад орж ирсэн суудлын тээврийн хэрэгслийг /9339 ОРБ/ балансын үнэ 29,800.0 мянган төгрөгөөр буюу бодит үнэ цэнээс

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон.

22,300.0 мянган төгрөгөөр өндөр дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС 17-ын 27-р параграфын шаардлагад нийцэхгүй байна.

Аудитаар нийт 6,367.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 410.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,956.8 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн

### 3.1 Төлбөрийн акт

Эрх бүхий этгээдийн холбогдох шийдвэргүйгээр төвийн дарга өөртөө 410.2 мянган төгрөгийн урамшуулал цалин авсан тул төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны бодогдсон нийт цалин үр дүнгийн тайлангаарх цалингийн зардлаас 2,598.1 мянган төгрөгийн зөрүүтэй, НДШ-ийн болон цалин хөлсний татварын тайлангийн цалингийн нийт дүнтэй тохирохгүй, цалин хөлсний татварын тайлангийн өмнөх оны 1,852.3 мянган төгрөгийн өглөгөөр цалингийн зардал бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.6 дахь хэсэгтэй тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НДШ-ийн болон цалин хөлсний татварын тайланг үнэн зөв гаргаж, бодогдсон цалинтай тулгаж, бодогдсон цалингийн дүнгээр цалингийн зардал бүртгэх.

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд болон өмнөх онд тэтгэвэрт гарсан 2 албан хаагчид тус бүр 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжид нийт 1,506.4 мянган төгрөгийг Эрүүл мэндийн газраас олгож буй Эрүүл мэндийн болон Төрийн албаны тухай хуульд заасан нэг удаагийн буцалтгүй тусламжаас гадна байгууллагын даргын "Хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай" тушаалаар шийдвэрлэж олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 4.4-д "Хэрэв Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад нь зориулж нэг удаагийн тэтгэмж олгох талаар заасан бол төрийн албан хаагч тэдгээр тэтгэмжийн аль илүүг сонгох эрхтэй ба энэ тохиолдолд тэтгэмжийг давхардуулан олгохгүй" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад олгож буй тэтгэмжтэй давхардуулан байгууллагаас тэтгэмж олгохгүй байх.

#### 3. Үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт Нийт албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг төлөвлөж батлаагүй, тухай бүр тушаал гарган ээлжийн амралт эдлүүлж байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2-д "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажилтнуудынхаа саналыг үндэслэн ээлжийн амралтын хуваарийг нэгдүгээр улиралд баталж хэвших.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруул аагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жаргалант сумын Эрүүл мэндийн төв	1	22,300.0			1	22,300.0	1	22,300.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>22,300.0</b>			<b>1</b>	<b>22,300.0</b>	<b>1</b>	<b>22,300.0</b>				

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/			
									Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жаргалант сумын Эрүүл мэндийн төв	1	410.2	1	410.2								
	1	0.0					1	0.0				
	1	4,450.4					1	4,450.4				
	1	1,506.4					1	1,506.4				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>6,367.0</b>	<b>1</b>	<b>410.2</b>			<b>3</b>	<b>5,956.8</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			